

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Тэргүүн
дэд даргын 2021 оны 27 дугаар тушаалын
27 дугаар хавсралт

АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

ИЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан үндэслэл:

- Төрийн албаны тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан шинэчлэн боловсруулсан
- Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон

Холбогдох хууль тогтоомжийн нэр, огноо:

Дагаж мөрдөх огноо:

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан огноо:

Байгууллагын нэр:

Засгийн газрын Хэрэг эрхлэх газар

Албан тушаалын нэр:

Нутгийн удирдлагын байгууллагын сургалт,
нутаг дэвсгэрийн нэгж хоорондын
харилцааны асуудал хариуцсан Засгийн
газрын референт

Ажлын цаг

Ажлын өдрийн 8 цаг

Хөдөлмөрийн нэхцөл:

Хэвийн

Орон нутгийн удирдлага, зохицуулалтын
газар

Албан тушаалын ангилал, зэрэглэл

Эрхэлсэн түшмэл, АА-5

Ажлын байрны албан ёсны байршил:

Улаанбаатар -12, Төрийн ордон

Онцгой нэхцөл:

Хамаарахгүй

АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ

Албан тушаалын зорилго:

Нутгийн удирдлагын байгууллагын төрийн албаны хүний нөөцийн асуудал, давтан сургалт,
гадаад харилцаа, гадаадын төсөл хөтөлбөрийн асуудлын ажлын үр дүн, үр нөлөөг
дээшлүүлэхэд чиглэсэн бодлогын удирдамж, зохицуулалт, үйлчилгээ, зөвлөгөө дэмжлэг
үзүүлэх.


Албан тушаалын зорилт:

- 1.Нутгийн удирдлагын байгууллагын төрийн албаны хүний нөөцийн асуудал, давтан сургалт, гадаад харилцаа, гадаадын төсөл хөтөлбөрийн ажлын үр дүн, үр нөлөөг дээшлүүлэхэд чиглэсэн арга хэмжээг зохион байгуулах;
- 2.Хариуцсан аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Тэргүүлэгчид, Засаг даргаас бүрэн эрхээ хэрэгжүүлж буй байдалд хяналт тавих, тэдгээрийн үйл ажиллагааг нэгдсэн удирдлага, зохицуулалтаар хангахад удирдлагыг мэргэжил, арга зүйн зөвлөгөө, дэмжлэгээр хангах.
- 3.Хууль тогтоомжид заасан нийтлэг үүргийг хэрэгжүүлэх.


Зорилт	Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хариуцлага, оролцооны хэлбэр Туслах-Т, Хариуцан гүйцэтгэх-Г Хянах-Х Шийдвэрлэх-Ш
1 дүгээр зорилтын хүрээнд	1.Нутгийн удирдлагын байгууллагын төрийн албаны хүний нөөцийн асуудлаар Засгийн газрын тухай хуульд ЗГХЭГ-ын даргад хүлээлгэсэн чиг үүргийг хэрэгжүүлэхэд чиглэсэн арга хэмжээг зохион байгуулах;	Хууль тогтоомжид нийцсэн үндэслэл бүхий байна.	Г, Х
	2.Нутгийн удирдлагын байгууллагын төрийн албан хаагчдын давтан сургалтын тогтолцоог бий болгох ажлыг холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулах;	Хуульд нийцсэн, үнэн зөв мэдээллээр хангасан байна.	Г, Х
	3.Нутгийн удирдлагын байгууллагын төрийн албан хаагчдын чадавхыг бэхжүүлэхэд чиглэсэн төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг бүх шатны байгууллагуудтай хамтран зохион байгуулах;	Хяналт тавьж, шийдвэрийн төсөл боловсруулсан байна.	Г, Х
	4.Аймаг, нийслэлийн гадаад харилцааг хөгжүүлэх, тэдгээрийг Монгол Улсын гадаад бодлогод нийцүүлэхэд чиглэсэн арга хэмжээг зохион байгуулах;	Мэргэжил арга зүйн ёндөр түвшинд зөвлөгөө, мэдээллээр хангасан байна.	Г, Х
	5.ЗГХЭГ-тай гадаад улс, олон улсын байгууллагаас хамтран орон нутагт хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийг хангахад нэгдсэн зохицуулалт, мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх;	Чиг үүргийн уялдааг хангаж, хэрэгжилтийг тооцсон байна.	
	6.ЗГХЭГ-тай гадаад улс, олон улсын байгууллагаас хамтран	Ажлын уялдааг хангаж зовшооров арга хэмжээний	Г, Х



	орон нутагт хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрийн үр дүн, үр нөлөөг сайжруулах санаачилга, бодлогын шийдвэрийн зөвлөмжөөр ЗГХЭГ-ын удирдлагыг хангах.	төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлсэн байна.	
2 дугаар зорилтын хүрээнд	1.Хариуцсан аймгийн Засаг дарга нарын бүрэн эрхээ хэрэгжүүлж байгаа байдалд хяналт тавих, тэдгээрийн үйл ажиллагааг нэгдсэн удирдлагаар хангах, удирдлагад зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх;	Хууль тогтоомжид нийцсэн мэргэжлийн зөвлөгөө, дэмжлэг үзүүлж, хяналт тавьж ажилласан байна.	Г, Х
	2.Ерөнхий сайд, ЗГХЭГ-ын удирдлага орон нутагт ажиллах бэлтгэлийг хангах, зохих үйлчилгээг үзүүлэх /маршрут, бүрэлдэхүүн, хэлэх уг, бусад бичиг баримтыг боловсруулах/;	Шуурхай, цаг хугацаанд нь үр дүнтэй бэлтгэл ажлыг хангасан байна.	Г
	3.Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүдийн орон нутагт ажилласны мөрөөр авах арга хэмжээ, шийдвэрийн төслийг боловсруулж, Засгийн газрын хуралдаанд оруулан шийдвэрлүүлэх;	Засгийн газрын хуралдаанаас гарч байгаа шийдвэр нь хууль тогтоомжид нийцсэн байна	Г, Х
	4.Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт, нутгийн захиргааны байгууллагын үйл ажиллагааны чиглэл, салбарын зарим асуудлаар хариуцсан аймгийн Засаг дарга нарын сонсгол, мэдээллийг бэлтгүүлж, Засгийн газрын хуралдаанд оруулах, гарах шийдвэрийн төсөл боловсруулах;	Хуулийн хүрээнд зохион байгуулалтын арга хэмжээ авсан байна.	Г
	5.Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайдаас аймгийн удирдлагад өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг тооцож танилцуулах	Биелэлтийг тооцож, удирдлагад танилцуулж, үнэн зөв мэдээллээр хангасан байна.	Г, Х
	6.Хариуцсан аймгийн нутгийн өөрөө удирдах болон захиргааны байгууллага, иргэдээс Ерөнхий сайд, Засгийн газарт хандаж тавьсан асуудал, өргөдөл, гомдол, санал хүсэлтийг холбогдох журмын дагуу судлаж, шийдвэрлүүлэх, Засгийн газраас цаашид хэрэгжүүлэх бодлого, чиглэлд тусгуулах арга хэмжээ авах;	Саналаа боловсруулж Засгийн газраас хэрэгжүүлэх бодлогод тусгасан байна.	Г, Х
	7.Төрийн захиргааны төв байгууллага, аймгийн ИТХ, Тэргүүлэгчид, Засаг дарга	Асуудлыг хуулийн хүрээнд шийдвэрлэх талаар холбогдох	



	нарын хоорондын ажиллагааг зохицуулах, орон нутгаас тавьсан асуудлыг шийдвэрлүүлэх чиглэлээр яам, агентлагтай ажиллах, орон нутгийн ажилтнуудад дэмжлэг зөвлөгөө үзүүлэх;	терийн байгууллагатай хамтран хэрэгжүүлсэн байна.	
	8.Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд аймаг, орон нутгаас шууд хариуцаж хэрэгжүүлэхээр тусгагдсан асуудлын явц байдалд хяналт тавьж, дэмжлэг зөвлөгөө үзүүлэх;	Хэрэгжүүлэхээр тусгагдсан ажлын биелэлтэд хяналт тавьж, хуулийн үндэслэлтэй зөвлөгөө, дэмжлэг үзүүлсэн байна.	Г, Х
	9.Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт, нутгийн захиргааны байгууллагын үйл ажиллагааны чиглэл, салбарын зарим асуудлаар хариуцсан аймгийн Засаг дарга нарын сонсгол, мэдээллийг бэлтгүүлж Засгийн газрын хуралдаанд оруулах, гарах шийдвэрийн төсөл боловсруулах;	Засгийн газрын хуралдаанаас гарч байгаа шийдвэр нь хууль зүйн үндэслэлтэй, боловсруулалтын шаардлага хангасан байна.	Г, Х
	10.Хариуцсан аймгуудын Засаг дарга нарын Ерөнхий сайдтай байгуулсан батламжийн хэрэгжилтийн байдалд хяналт тавьж зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх;	Батламжийн хэрэгжилтэд хяналт тавьж, тухай бүрт танилцуулсан байна.	Г
	11.Хариуцсан аймгуудын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, эдийн засаг, нийгмийн үндсэн чиглэлийн хэрэгжилтэд хяналт тавьж, зөвлөгөө өгөх;	Хэрэгжилтэд хяналт тавьж, шуурхай зөвлөгөө, дэмжлэг үзүүлсэн байна.	Г, Х
	12.Хариуцсан аймгийн ИТХ, Тэргүүлэгчид, Засаг дарга, Тамгын газрын үйл ажиллагаатай газар дээр нь танилцах, мэргэжил, арга зүйн зөвлөгөө дэмжлэг үзүүлэх, эдийн засаг, нийгмийн хөгжлийн болон бусад асуудлаар судалгаа шинжилгээ хийх, доголдож буй асуудлыг шийдвэрлэх талаар үүрэг чиглэл өгөх, биелэлтийг дүгнэх;	Тухай бүрт шинжилгээний үр дүнд тулгуурласан санал боловсруулж шийдвэрлэх талаар холбогдох арга хэмжээ авсан байна.	Г, Х
	13.Байгуулагдсаны тэгш ой тэмдэглэх хариуцсан аймаг, суманд Ерөнхий сайдаас явуулах илгээлт, мэндчилгээ боловсруулах, хэвлүүлж, хургуулэх;	Цаг хугацаанд нь төлөвлөн хийж гүйцэтгэсэн байна.	Г, Х



	<p>14. Засгийн газрын гишүүд, ЗГХЭГ-ын удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг цаг хугацаанд нь чанартай гүйцэтгэж, эргэн тайлгах;</p>	<p>Ажлын гүйцэтгэлийг шуурхай, чанартай хийж гүйцэтгэсэн байна.</p>	Г
	<p>15. Хариуцсан аймгуудад Засгийн газар, удирдлагаас өгсөн үүрэг, даалгаврын биелэлт, түүний явц, үр дүн, өмнө нь Ерөнхий сайд тухайн аймагт очиждоо өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилт, аймгуудаас тавьсан тулгамдаж буй асуудал зэрэг судалгааг гарган тогтмол баяжилт хийж, удирдлагыг нэгдсэн мэдээллээр хангаж байх;</p>	<p>Үүрэг даалгаврын хэрэгжилт, тулгамдсан асуудлын судалгааг тогтмол гаргаж удирдлагыг үнэн зөв мэдээллээр хангасан байна.</p>	Г, Х
	<p>16. Улсын тэргүүний /загвар/ сум шалгаруулах болзлын биелэлтийг дүгнэх ажиллагаанд оролцох.</p>	<p>Холбогдох журмын дагуу шалгаруулсан байна.</p>	Г, Т
3 дугаар зорилтын хүрээнд	<p>1. ЗГХЭГ-ын удирдлага, нэгжийн даргаас өгсөн хуульд нийцсэн үүрэг даалгаврыг биелүүлэх, Ерөнхий сайдын захирамж, ЗГХЭГ-ын даргын тушаалаар байгуулсан холбогдох Ажлын хэсэгт орж ажиллах;</p>	<p>Холбогдох хууль тогтоомжид нийцсэн байна</p>	Г
	<p>2. Засгийн газар, Ерөнхий сайд, ЗГХЭГ-т төрийн захиргааны бүх шатны байгууллага, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллага, иргэдээс ирсэн санал хүсэлтийг хууль тогтоомжид нийцүүлэн шийдвэрлэхтэй холбоотой зөвлөгөө, үйлчилгээгээр удирдлагыг хангах, асуудлыг судалж хариу төлөвлөх, холбогдох байгууллага, албан тушаалтанд шилжүүлэх асуудлыг судалж удирдлагад танилуулж зохих журмын дагуу шийдвэрлэх;</p>	<p>Холбогдох хууль тогтоомжид нийцсэн байна</p>	Г
	<p>3. Эрхэлсэн ажил үүргийн хүрээнд шийдвэрлэсэн асуудлын хяналтын картыг тухай бүрт нь хаах, үйл ажиллагааны явцад гарсан баримт бичгийг ангилан хэрэг бүрдүүлж, Засгийн газрын архивт зохих журмын дагуу шилжүүлсэн байх;</p>	<p>Холбогдох хууль тогтоомжид нийцсэн байна</p>	Г
	<p>4. Тухайн албан тушаалын чиг үүргийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан холбогдох нууцын баталгааг авахад шаардагдах материалыг гаргаж</p>	<p>Холбогдох хууль тогтоомжид нийцсэн байна</p>	

	өгөх.		
III.АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА			
Боловсрол	Бакалавр ба түүнээс дээш боловсролын зэрэгтэй байх.		
Мэргэжил	<p>-нийгмийн шинжлэх ухаан (031); -эрх зүй (0421); -удирдахуйн ухаан (0413); -эдийн засаг (0311).</p>		
Мэргэшил	Эрхэлсэн түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад хамрагдаж төгссөн байх.		
Туршлага	Төрийн албанад 12-оос доошгүй жил, үүнээс ахлах түшмэлийн албан тушаалд 4-өөс доошгүй жил ажилласан байх.		
Ур чадвар	Удирдан зохион байгуулах	<ul style="list-style-type: none"> - эрсдэлийн удирдлагад суурилсан хяналтыг хэрэгжүүлэх ажлын гүйцэтгэл, үр дүнг хариуцаж, үүрэг, хариуцлага хүлээх; - байгууллагын алсын хараа, эрхэм зорилго, үнэт зүйлс, стратегийг хэрэгжүүлэх; - ажлаа төлөвлөх, зохион байгуулах, тайлагнах; - хууль зүйн бичлэгийн техник болон практик ур чадвар эзэмшсэн байх; - саналын зөрүү, үл ойлголцлыг эв зүйгээр зохицуулах; - бусад. 	
	Дун шинжилгээ хийх	<ul style="list-style-type: none"> - төсөлд эрх зүйн дүгнэлт хийх; - төслийн заалтын шууд ба шууд бус үр дагаврыг тооцож шийдлийн хувилбар боловсруулах; - мэдээлэлд тулгуурлан харьцуулсан шинжилгээ хийх; - бодлогын үндэслэлтэй дүгнэлт, зөвлөмж, тайлбар бэлтгэх; - бусад. 	
	Асуудал шийдвэрлэх	<ul style="list-style-type: none"> - Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуулийг чандлан баримталж, үндэсний язгуур ашиг сонирхолд захирагдан ард түмэндээ үйлчилж, төрд чин үнэнчээр зүтгэх; - аливаа асуудлыг албан тушаалын бүрэн эрхийн хүрээнд хууль болон ёс зүйн зарчимд нийцүүлэн ашиг сонирхлоос ангид шийдвэрлэх; - хуульд нийцсэн, бодит баримт нотолгоонд тулгуурласан, үндэслэл бүхий үнэн зөв мэдээлэл, мэргэжлийн зөвлөгөөгөөр хангах; - хийсэн ажлынхаа гүйцэтгэл, үр дүнгийн төлөө бүрэн хариуцлага хүлээх; - бусад. 	
	Манлайлах	<ul style="list-style-type: none"> - төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг сахиж, ёс зүйгээр бусдыг манлайлах; - ажил хэргийн хувьд бүтээлч, санаачилгатай ажиллах; - хувийн зохион байгуулалт, цаг ашиглалтын хувьд бусдыг манлайлах; - байгууллагын болон нэгжийн үйл ажиллагааны шинэтгэлийн үзэл санааг бусдад итгээж бийгүүлэх, хэрэгжүүлэх; - бусад. 	
	Бусад	<ul style="list-style-type: none"> - албан хэрэг хөтлөх, баримт бичиг бийгүүлэх; - хууль зүйн техникийн болон практик ур чадвар эзэмшсэн байх; 	



	<ul style="list-style-type: none"> - англи хэл, эсхүл бусад гадаад хэлээр албан тушаалын чиг үүрэгт хамаарах мэдээллийн эх сурвалжийг ашиглах чадвартай байх; - компьютерын хэрэглээний програм, мэдээлэл харилцааны технологийг ашиглах чадвартай байх; - багаар ажиллах, мэдээллээ хуваалцах; - иргэн, албан тушаалтан, гишүүдтэй зелдэг, соёлтой, хүндэтгэлтэй харилцах; - худалдан авах ажиллагааны сургалтад хамрагдаж АЗ гэрчилгээ авсан байх; - төрийн нууцтай танилцах эрх олгохтой холбоотойгоор аюулгүй байдлын шалгалт явуулахыг бичгээр зөвшөөрч, эрх бүхий байгууллагын аюулгүй байдлын шалгалтад хамрагдаж, тэнцсэн байх; - кирилл болон үндэсний бичгээр албан хэрэг боловсруулах чадвартай байх.
--	---

IV.АЛБАН ТУШААЛТНЫ ХАРИЛЦАХ СҮБЬЕКТ

Албан тушаалыг шууд харьялан удирдах албан тушаалын нэр:

- Орон нутгийн удирдлага, зохицуулалтын газрын дарга.

<u>Албан тушаалд шууд харьялан удирдуулах албан тушаалын нэр, тоо:</u>	<u>Бусад харилцах субъект:</u>
	<ol style="list-style-type: none"> 1.Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Тэргүүлэгчид, удирдлага, Ажлын алба; 2.Аймаг, нийслэлийн Засаг дарга, Тамгын газар; 3.Яам, агентлаг, төрийн бусад байгууллагын холбогдох албан тушаалтан; 4.Улсын Их Хурлын болон Ерөнхийлөгчийн Тамгын газар, Үндэсний аюулгүй байдлын зөвлөл, Үндсэн хуулийн цэц, Төрийн албаны зөвлөл, тэдгээрийн Ажлын албаны холбогдох албан тушаалтан; 5.Иргэн, хуулийн этгээд.

V.АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ

<u>Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан:</u>	<u>Албан тушаалын тодорхойлолтыг хяналж, батлах зөвшөөрөл олгосон байгууллагын шийдвэр:</u>
<u>Албан тушаал:</u> ДЭД ДАРГА  У.БЯМБАСҮРЭН 2021 оны ... дугаар сарын ... -ны өдөр	Байгууллагын нэр: ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ Шийдвэрийн огноо: 27 09 14 Дугаар: 219

Албан тушаалын тодорхойлолт баталсан:

Байгууллагын нэр:

ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

Шийдвэрийн огноо: Тэргүүн дэд даргын 2021 оны 09 дүгээр сарын 22-ны өдрийн тушаал

Дугаар: 211

(тамга/тэмдэг)

ТЭРГҮҮН ДЭД ДАРГА

2021 оны 09 дүгээр сарын 22-ны өдөр



Б.ГАНБАТ

(Эцэг/эх-/ийнчилэр, өөрийнчилэр)

